



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/250

Булган сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн , Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.2.1 дэх заалт, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 3.5 дахь зорилтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн үйл ажиллагааны хүрээнд идэвхтэй хөдөлгөөн, эрүүл амьдралын хэвшил бүхий иргэн, гэр бүлийг дэмжих, биеийн тамир спортоор хичээллэх ач холбогдлыг ойлгуулах мэдлэг мэдээлэл олгох, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилготой “Эрүүл хандлага- Эрүүл нийгэм” аяныг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Батчимэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: Х.Батхишиг (Биеийн тамир спортын газрын дарга)
Ж.Халиунаа (Хөгжимт жүжгийн театрын дарга)
С.Нарантуяа (Эрүүл мэндийн газрын дарга)
А.Гантөмөр (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
дарга)
Л.Ганболд (Биеийн тамир спортын газрын албаны
дарга)

Нарийн бичгийн дарга: Ё.Хулан (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн Соёл, спорт хариуцсан
бодлогын мэргэжилтэн)

2. Дээрх ажлыг чанартай зохион байгуулж, үр дүнг хугацаанд нь тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч (М.Батчимэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



Сандг Ажлг 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

6323010233